

үйлчилгээг үндэслэл бүхий цогц судалгааны ажил дээр тулгуурлан оновчтой байдлаар тасралтгүй хэрэгжүүлэх нь ялтныг сөрөг үйлэл хийхээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн дээрхи онцлогуудтай уялдуулан сэтгэл зүйн үйлчилгээг хүртээмжтэй, үр дүнтэй болгох зорилгоор дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Ялтны сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж буй шалтгаан нөхцлийг судлан илрүүлэх, түүнд тулгуурлан мэргэжлийн үйлчилгээг явуулах.
2. Сэтгэл зүйн суурь судалгааны ажлуудын үр дүнг дэглэмийн онцлог тус бүрээр нь нэгтгэн тодорхойлох, нэгдсэн сан бүрдүүлэх, түүнд тулгуурласан нарийвчилсан арга зүйг боловсруулах.
3. Хорих ангид ялтныг ялгамжтай байршуулах ажлыг хэрэгжүүлэхдээ зөвхөн давтан шийтгэгдсэнийг бус бусад бие хүний хувийн онцлогийг харгалзан авч үзэж байх.
4. Хорих байгууллагад явуулах сэтгэл зүйн үйлчилгээний нэгдсэн стандарт, мэргэжлийн ажиллах орчин, ажлын ачаалал, мэргэжлийн үйлчилгээний талаар хууль эрх зүйн бичиг баримтанд тусгах.
5. Шийтгэгдсэнийг бус бусад хувийн онцлогийг давхар харгалзан үзэж хэвших,
6. Хорих ангийн дарга, дэд дарга, даргын зөвлөлийн оролцоотойгоор ялтны дунд энгийн ярилцлага тогтмол зохион байгуулж байх
7. Хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөн дэмжиж байх,
8. Шаардлагатай бол тэдний цагийн хуваарьт өөрчлөлт оруулах
9. Урлаг соёл, спортын болон бусад олон нийтийн байгууллага, түүнчлэн хувь уран бүтээлчидтэй хамтран ажиллаж, нөлөөлөл үзүүлэх гэх мэт.

## Г.ТАМИР



Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, хурандаа

### ОНЦГОЙ ДЭГЛЭМТЭЙ ХОРИХ АНГИД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олон нийтээс тусгаарлаж, тодорхой хугацаагаар хязгаарлагдмал орчинд албадлагаар тогтоон барьдаг өөрөөр хэлбэл гэмт хэрэгтнүүдийн оршин амьдрах нийгмийн бичил орчин болдог. Энэхүү орчинд үйлдэгддэг гэмт явдлуудын шалтгаан, нөхцөлүүд нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой бөгөөд уг асуудлыг криминологийн шинжлэх ухааны салбар болох Пенитенциар гэмт явдал судлал шинжлэн судалдаг.

Пенитенциар гэмт явдал судлал нь хорих ангид үйлдэгддэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл түүнийг шийдвэрлэх арга замыг судлахдаа өнөөгийн хорих байгууллагын төрөл, дэглэмийн ялгаа, тэнд ял эдлэгсдийн онцлог, хэм хэмжээ зэргийг харгалзах учиртай.

Хорих ангид үйлдэгддэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл нь хорих ангийн төрөл, дэглэм, ял эдлэгсдийн онцлогоос хамаарч харилцан адилгүй байх тул онцгой дэглэмтэй хорих ангид үйлдэгдэж болзошгүй гэмт явдлаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай гэж судлаачийн зүгээс үзсэн болно. Учир нь хорих ангийн төрөл, дэглэм нь ял эдлэгсдийг тодорхой шинжүүдээр төрөлжүүлэхийн хамт эрх зүйн зан үйлийн ялгаатай орчинг бий болгодог. Тухайлбал: Онцгой дэглэмтэй хорих ангид онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, рецетив гэмт

хэрэгтнүүд ял эдэлдэг бол жирийн дэглэмтэй ялтнууд нь нийгэмд аюултай шинж буюу зан төлөвийн доголдол бага байдаг. Түүнчлэн хорих ангид мөрдөгдөх дэглэм, журам, хэм хэмжээ, харуул хамгаалалтын хүч хэрэгсэл нь хорих байгууллагын төрөл, дэглэмээс хамаарч ялгаатай байдаг.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд түүний шалтгаан

хувилбаруудаас хамгийн оновчтойг нь сонгох;

5. Төлөвлөх буюу төлөвлөгөө боловсруулах;

6. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

7. Урьдчилсан хяналт;

8. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд тавих явцын хяналт;

9. Гүйцэтгэл буюу төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэх;

10. Буцах холбоо буюу гэмт явдлаас



нөхцлийг судалж, дүн шинжилгээ хийх нь дээрхи зорилгод хүрэх арга зам гэж үзэж байна.

Хорих ангид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь дараах үе шатыг дамжин хэрэгждэг. Тухайлбал:

1. Нөхцөл байдлын шинжилгээ, оношлогоо. Онцгой дэглэмтэй хорих ангид урьд нь гарч байсан гэмт явдлын бүтэц, тэдгээрийн шалтгаан нөхцөл, хорих ангийн гадаад, дотоод хүчин зүйлүүдийн нөлөөллийн түвшин, харилцан хамаарал, түүнчлэн чиг хандлагыг урьдчилан тодорхойлох;

2. Зорилго ба төлөвлөгөөний хувилбаруудыг боловсруулах. Өөрөөр хэлбэл гэмт явдлын шалтгаан, нөхцөл, хүчин зүйлүүдийг арилгах, нөлөөллийн түвшинг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийн хувилбаруудыг боловсруулах;

3. Хувилбаруудыг үнэлэх. Боловсруулсан хувилбаруудыг эерэг, сөрөг тал, ач холбогдолыг тооцож эрэмбэ, дараалалд оруулах;

4. Хувилбаруудыг сонгох. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлүүдийн арилгахад чиглэсэн

урьдчилан сэргийлэх ажиллагааг боловсронгуй болгох өөрөөр хэлбэл төлөвлөлтийг шинэчлэх;

Хорих анги дахь гэмт явдлыг зөвхөн Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүдээр хязгаарлан ойлгож болохгүй. Гэмт явдал нийгмийн сөрөг үзэгдэл болохын хувьд түүнийг бүрдүүлэгч элементүүд нь гэмт хэрэг, сахилгын зөрчил, ёс зүйн зөрчил, зан заншлын хэм хэмжээний зөрчил хэлбэрээр илэрдэг<sup>36</sup>. Тэгэхээр хорих байгууллага дахь гэмт явдал нь ял эдлэх, эдлүүлэх үүрэг бүхий хүмүүсээс үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд дараах схемээр тайлбарлаж болох юм. /Зураг 01/

Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судлахгүйгээр түүнээс урьдчилан сэргийлэх зорилгод хүрэхгүй талаар дээр өгүүлсэн. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь харилцан уялдаатай боловч хоорондоо ялгаатай ойлголт юм.

Гэмт явдлын шалтгаан -Гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэж буй нийгмийн үзэгдэл, үйл явц, түлхэц

<sup>36</sup> Г.Эрдэнэбат, Б.Батзориг, Г.Туяа "Криминологи" УБ,2013



**Гэмт явдлын нөхцөл** - Гэмт хэрэг, зөрчил үйлдэх таатай нөхцөл, боломж юм. Гэмт явдлаас урдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулахад уг үйл явцын шалтгаан нөхцөлөөс гадна түүнд нөлөөлөх хүчин зүйлүүдийн үйлчлэл, харилцан хамаарал, нөлөөллийн төвшин зэргийг тодорхойлох учиртай.

Хорих байгууллага дахь гэмт явдалд нөлөөлж буй шалтгаан нөхцөл, хүчин зүйлүүдийг судлахаас гадна гэмт явдлын онцлог, түүний хор уршиг, гэмт этгээд, хохирогч, тэдгээрийн онцлог, бие хүн болж төлөвших зүй тогтол, урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр нөлөө зэргийг судалсны үндсэн дээр гэмт явдлыг бууруулах, таслан зогсоход чиглэсэн цогц арга хэмжээг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэнэ.

Хорих ангид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг объектоор нь:

А. Ялтны хүрээнд гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа;

Б. Албан хаагчдын дунд зохион байгуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа;

В. Хорих ангийн ойролцоо оршин суух иргэдэд чиглэсэн ажиллагаа;

**Хамрах хүрээгээр нь:**

А. Хорих байгууллагын хэмжээнд;

Б. Тодорхой хорих анги, бүлэг хүмүүсийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа;

В. Тодорхой хувь хүн, ялтныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажиллагаа;

**Гэмт явдлын шалтгаан, нөхцөл, хүчин зүйлүүдийн цар хүрээ, хэмжээнээс хамаарч:**

А. Хорих ангийн хэмжээнд шийдвэрлэхүйц үйл ажиллагаа;

В. Хамтран ажилладаг байгууллагын хүрээнд шийдвэрлэх үйл ажиллагаа;

Г. Удирдах дээд байгууллагын түвшинд шийдвэрлэх үйл ажиллагаа;

Д. Макро түвшний асуудал; /Хууль тогтоомжийг боловсронгуй болгох,

хөрөнгө санхүү, хүн ам зүй, амьжиргааны түвшин, хүмүүсийн үзэл хандлага, үнэлэмжтэй холбоотой асуудал/ гэх мэтээр тус тус ангилж болно.

Монгол Улсын хэмжээнд онцгой дэглэмтэй хорих анги ганцхан байдаг явдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг өвөрмөц байдлаар зохион байгуулах шаардлагыг бий болгодог. Тухайлбал: Хорих ялыг ялгамжтайгаар эдлүүлэх, ялтны аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зарим ялтныг өөр хорих анги руу шилжүүлэх шаардлага бий болдог. Гэтэл онцгой дэглэмтэй хорих ангид ингэх боломж байхгүй.

Хорих байгууллагын үйл ажиллагаа, ялангуяа харуул хамгаалалт нь бүхэлдээ гэмт явдлаас урьдчилан сэргийлэх зорилгод чиглэсэн байдаг. Онцгой дэглэмтэй хорих ангид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхдөө хорих ангийн орчин, түүнд хамаарах хүчин зүйлүүдийн нөлөөллийн түвшин буюу бодит нөхцөл байдлыг тодорхойлох шаардлагатай тухай дээр өгүүлсэн. Байгууллагын орчин нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой бүхий л мэдээллийг өөртөө агуулдаг бөгөөд байгууллагын үйл ажиллагааны эцсийн үр дүнд эерэг, сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлүүдийн нийлбэр<sup>37</sup>, түүний нөлөөллийн түвшинг илэрхийлдэг.

Онцгой дэглэмтэй хорих ангийн гадаад орчны хүчин зүйлүүдэд:

1. Байгаль, цаг уур, газар зүйн орчин. Онцгой дэглэмтэй хорих анги нь төв суурин газраас алслагдсан бүсэд байрлаж буй явдал нь хүний зайлшгүй хэрэгцээ болох гар утастай холбоотой зөрчил гарахгүй байх, ялтны гэмт үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээлэл дамжуулах хурдыг багасгах,

<sup>37</sup> Н.Цэнд, Н.Батхүрэл, Я.Шуурав, Х.Пүрэвдагва, Ц.Цэцэгмаа, нарын хамтын бүтээл "Менежмент" сурах бичиг, УБ, 2013

гэмт үйл ажиллагаа нь шууд ард иргэдэд чиглэх боломжийг бууруулах гэх мэт олон эерэг нөлөөлөлтэй боловч гэмт явдлыг таслан зогсоох үйл ажиллагаанд албан хаагчдын хүчийг нэмэгдүүлэх, бусад байгууллагаас тусламж, дэмжлэг авахад хугацаа алдах, албан хаагчид тогтвор сууршилтай ажиллахгүй байх гэх мэт олон сөрөг үр дагавартай. Мөн газар зүйн орчин нь хангайн уулархаг бүсэд, байгалийн бартаа саад ихтэй, модлог газарт оршдог. Иймд ялтан оргосон тохиолдолд байгалийн бартаа саадыг ашиглан нуугдах боломжтой. Байгаль, цаг уурын хувьд Монгол улсын жилийн дундажтай адил.

2. Ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн орчин. Ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн орчин, түүний тодорхой бус, зөрчилдсөн байдал нь гэмт явдлын шалтгаан болж болох бөгөөд уг ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг бүхэлд нь боловсронгуй болгох шаардлага тулгараад байна. Тухайлбал хуучин нийгмийн үед зохицож байсан ял эдлүүлэх байгууллагын төрөл, дэглэмийн асуудал өнөөгийн нийгмийн хөгжлийн шаардлагад нийцэхгүй болсон нь хорих ялын үр нөлөө буурч байгаагаар тайлбарлагдана. Нөгөө талаар хүний эрхийг хангах дэд бүтцийг бүрдүүлэхгүйгээр /ял эдлүүлэх ажиллагааны реформ хийх/ ялтны эрх ашгийг хэт дээгүүрт тавьснаас ялтны дураар авирлах байдал, албан хаагчдыг үл тоох, тэдэн рүү дайрч давшлах асуудал газар авч улмаар тэднийг хорих байгууллагад тогтвортой ажиллах эсэхэд нөлөөлөх хэмжээнд хүрлээ. Түүнчлэн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьдаг, хамтран ажилладаг байгууллага, иргэдийн зүгээс хорих байгууллагын албан хаагчид ялтандаа шаардлага тавьж чадахгүй болжээ гэсэн шүүмжлэл өнгөлзөх боллоо.

3. Хорих байгууллагатай хамтран ажилладаг байгууллага, иргэдийн үйл ажиллагаа. Хорих байгууллагатай

хамтран ажилладаг байгууллага, иргэдийн шийдвэр, үйл ажиллагаа нь гэмт хэргийн шалтгаан болж болно. Тухайлбал. Ялтныг дэглэмийг чангаруулах тухай хуулийн заалтыг шүүхийн практикт олон янзаар тайбарлан, хэрэглэж байгаа явдал нь ялтнаас гаргаж буй зөрчлийг өөгшүүлэх нэг шалтгаан болдог. Мөн онцгой дэглэмтэй хорих ангид гэмт хэрэг үйлдсэн ялтныг шийтгэхдээ ял эдлэх дэглэмийг хэвээр нь үлдээснээр уг ялтныг өөгшүүлж, бусад ялтнуудын сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлдэг.

4. Ялтнуудын гаднах хань харилцаа буюу найз нөхөд, ар гэр, гэмт хэргийн хамтрагчид, тэдгээрийн хандлага, хорих байгууллага, ялтанд нөлөөлөх нөлөөллийн төвшин. Жнь: Улс төр, бизнесийн тодорхой бүлэглэлүүд өөрсдийн эрх ашгийг хамгаалах, хууль бус үйлдэлдээ ашиглах зорилгоор эрүүгийн ертөнцөд дархлаагаа тогтоосон гэмт хэрэгтнүүдийг сонирхон судлах, хүрээлэлдээ элсүүлэх хандлага ажиглагддаг. Иймээс ялтнууд шоронд өөрийн нөлөөллийн түвшинг нэмэгдүүлэх, улс төр, бизнесийн бүлэглэлийн сонирхолыг татахын тулд хорих ангийн дэглэм журмыг зөрчих, гэмт хэрэг үйлдэх, зохион байгуулах хандлага гаргаж болзошгүй. Мөн ялтны гэр бүлийн асуудал оргох гэмт хэргийн шалтгаан болдог.

5. Улс төрийн байдал, хууль эрх зүй, эдийн засаг, гадаад улс орнуудын харилцаа гэх мэт хүчин зүйлүүд хамаарна. Гадаад орчны хүчин зүйлүүдийг дотор нь шууд нөлөөлөх микро, шууд бус нөлөөлөх макро хүчин зүйл гэж ангилж болно.

Онцгой дэглэмтэй хорих ангийн дотоод орчинд дараах зүйчин зүйлс хамаарна. Үүнд:

1. Хорих ангийн удирдлага зохион байгуулалт. Энэ нь байгууллагын удирдах бүрэлдэхүүний мэдлэг, ур чадвар, байгууллагын үйл ажиллагааг уялдуулан



зохион байгуулах эв дүй ямар түвшинд байгааг илэрхийлэх ойлголт юм. Ялтны дундаас гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний далайц, үр дүн нь үндсэндээ байгууллагын удирдах бүрэлдэхүүнээс шалтгаална.

2. Онцгой дэглэмтэй хорих ангийн албан хаагчдын мэдлэг чадвар, дадлага туршлага, албандаа хандах хандлага, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн төвшин. Онцгой дэглэмтэй хорих ангийн газар зүйн байршил, ажлын онцлогоос хамаарч албан хаагчид тогтвор сууршилтай ажиллахгүй байгаагаас харуул хамгаалалтын бүрэлдэхүүн нь ялтнуудаасаа эсрэг хамааралтай болсон. Өөрөөр хэлбэл ял эдлэгсэд нь олон удаа, удаан хугацаагаар хорих ял эдэлж нэг үгээр шоронжсон хүмүүс байдаг бол тэнд ажиллаж буй албан хаагчид ихэвчлэн шинээр томилогдсон, ажлын арга туршлага багатай хүмүүс байгаа нь удирдах ажилтнуудыг санааг зовоосон асуудал болоод байна.

3. Ялтны эрүүгийн нөхцөл байдал. Энэ нь ял эдлэгсдийн үйлдсэн гэмт хэргийн төрөл /Онц хүнд, хүнд, хүндэвтэр, хөнгөн/, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон рецитив гэмт хэрэгтний эзлэх хувь ямар түвшинд байгааг илэрхийлнэ. Сүүлийн 6 жилийн дундаж тоон үзүүлэлтээр онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон ялтан нийт ялтны дотор 60 гаруй хувь, хүн амины гэмт хэрэг үйлдсэн ялтны тоо 50-аас дээш хувийг тус тус эзлэж байна. Түүнчлэн нийт ял эдлэгсдийн дийлэнхи олонх нь 2 буюу түүнээс дээш давтан гэмт хэрэг үйлдэгсэд байгаа нь эрүүгийн нөхцөл байдал хүнд байгааг харуулдаг.

4. Ялтны доторх гал хам, бүлэглэлүүдийн бүтэц, зохион байгуулалт, зорилго, чиглэл, задрал, нягтрал, хөдөлгөөн, манлайлагч, удирдагчийн хандлага, байр суурь зэргийг анхааралтай ажиглаж, түүнийг зөв чиглэлд алсаас удирдах нь онцгой

дэглэмтэй хорих ангид томоохон чухал асуудлуудын нэг мөн.

5. Барилга байгууламж, хамгаалалтын техник хэрэгсэл, тэдгээрийн хүрэлцээ. Хорих 439-р ангийн хамгаалалтын барилга байгууламж, ялтны амьдрах нөхцлийг сайжруулах, хамгаалалтын техник хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ШШГЕГ-аас сүүлийн жилүүдэд шат дараатай арга хэмжээ авсаны үр дүнд тодорхой ахиц дэвшил гарч байна. Тухайлбал хорих анги дахь хяналтын камерийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоход зохих үр дүнгээ өгч байна.

6. Үйлдвэрлэлийн чиглэл, онцлог, ялтны хөдөлмөр зохион байгуулалтын асуудал. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудал нь ялтныг хөдөлмөрөөр хангах үйл ажиллагаатай зарим талаар зөрчилддөг. Тухайлбал. Ялтныг хөдөлмөрөөр хангах, тэднийг цалинжуулж, хохирол төлбөрийг барагдуулах зорилгоор төрөл бүрийн ажлын байр бий болгож, хөдөлмөр эрхлүүлэх нь гэмт хэрэг үйлдэх таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Хөдөлмөрийн багажаа зэвсэг бэлтгэхэд ашиглах, зэвсэг болгох, хөдөлмөр эрхлэх явцдаа харуул хамгаалалтын сул байдлыг ашиглан оргох зэрэг асуудал гаргаж болзошгүй.

Хорих 439-р ангид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд тулгамдаж буй томоохон асуудлуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

**Нэг. Ялтны дотор гал, хам, бүлэглэл бэхжих болсон.**

Хорих ангийн зүгээс гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ялтны аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт ялтнуудыг хоорондоо харьцах боломжгүй хэд хэдэн бүсэд тусгаарласан /4 хэсэг болгож хуваасан/ явдал нь эерэг сөрөг үр дүнг араасаа дагуулж байна. Тухайлбал. Гэмт хэрэг гарч болзошгүй тодорхой

нөхцөлийг /тусгаарлах замаар/ арилгах боломжийг бүрдүүлэх сайн талтай боловч ялтны гал хам, бүлэглэлүүдийг бэхжүүлэх улмаар зохион байгуулалттай бүлэглэл үүсэх, харуул хамгаалалтын хүч тарамдах шалтгаан болж байна. Ялтны доторхи бүлэглэл бэхжих, цуллаг байдал үүсэх нь олон төрлийн сөрөг үр дагаварыг үүсгэдэг. Тухайлбал:

1. Нийтийг хамарсан зохион байгуулалттай үйл ажиллагаанд нийт ялтнууд татагдан орох магадлалыг нэмэгдүүлэх;

2. Хорих ангийн дэглэм журмыг сахиулах талаар албан хаагчийн тавьсан шаардлагыг нийтээрээ эсэргүүцэх;

3. Албаны зүгээс бүлэглэлд нэвтрэлт хийх, мэдээ, мэдээлэл олж авах боломжийг багасгах;

4. Нөлөө бүхий ялтны байр суурь бэхжих;

5. Нууц далд гэмт явдал цэцэглэх, хөгжих зэрэг олон сөрөг үр дагавар үүсэх шалтгаан болдог байна.

**Хоёр. Ялтны тоо өсөх хандлагатай байна.**

Хүмүүс өөр хоорондоо харилцах, мэдээлэл солилцох явдал нь төрөлхийн хэрэгцээ мөн. Тиймээс ялтны гар утас, хэрэглэх, хадгалахтай холбоотой зөрчлийг бууруулах, таслан зогсоох нь хорих байгууллагын өмнө тулгамдсан асуудлын нэг болоод байна. Чухам энэ асуудалтай холбоотойгоор дэглэм нь чангарч онцгой дэглэмд ял эдлэх хүмүүсийн тоо жил тутам нэмэгдсээр байна<sup>38</sup>. Иймд ял эдлэгсдийн тоо өссөнтэй холбоотойгоор гарч болзошгүй гэмт явдлын тоо өсөх хандлагатай. Гэхдээ гэмт явдлын өсөлт бууралтыг механикаар харах биш, нийт ял эдлэгсдийн тоонд харьцуулж, чанарын өөрчлөлтөнд анхаарлаа хандуулах учиртай.

**Гурав. Хүний нөөцөд асуудал хуримтлагдсаар байна.**

Ажлын нөхцөл, ачаалал, газар зүйн онцлогоос хамаарч албан хаагч тогтвор сууршилтай ажиллахгүй байх, туршлагатай, мэргэшсэн боловсон хүчний дутагдалд орох, хүний нөөцийг бүрдүүлэхэд хүндрэл учрах зэрэг нь хүний нөөцийн чиглэлээр тусгайлсан бодлого баримтлах шаардлагатайг харуулж байна. Энэхүү байдал нь гэмт явдлын нөхцөлийг бүрдүүлдэг.

**Дөрөв. Ялын бодлоготой уялдан ялтны сэтгэл зүйд өөрчлөлт орсон.**

Цаазаар авах ялыг гүйцэтгэлийг түтгэлзүүлсэнтэй холбоотойгоор ялын дээд хэмжээ, хорих ялын дээд хязгаар хоёрын ялгаа зааг багассан. Өөрөөр хэлбэл 25 жилийн хорих ялаар шийтгүүлсэн ялтан ямарч ноцтой гэмт хэрэг үйлдсэн 5 жилээр л ялаа нэмүүлэх юм байна гэсэн ойлголт, хандлага ялтны дотор цухалзах болсон нь хорих байгууллага ялангуяа онцгой дэглэмтэй хорих ангийн аюулгүй байдалд шинэ заналхийллийг бий болгосон.

**Тав. Ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь өнөөгийн шаардлагад нийцэхгүй болсон.**

Хорих ял эдлүүлэх ажиллагааг боловсронгуй болгох, хорих ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд ял эдлэх ахуй, орчин, нөхцлийг сайжруулах, олон улсын эрх зүйн зохицуулалтын аргыг өөрийн орны хөрсөнд буулгах тухай асуудлаар хязгаарлаж болохгүй.

Хорих ялын үр нөлөө нийгмийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь давтан гэмт хэрэгтний тоон үзүүлэлт буурахгүй байгаагаар шууд тайлбарлагдана<sup>39</sup>. Өөрөөр хэлбэл шоронд ял эдэлсэн хүмүүс засарч хүмүүжих бус харин ч шоронжоод, гэмт хэрэг үйлдэх

<sup>38</sup> Хорих 439-р ангийн тоо бүртгэл, судалгааны тайлан мэдээ, Сүүлийн 5 жилийн байдлаар

<sup>39</sup> Г.Тамир, “Онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” магистрын дипломын ажил, УБ,2013



арга, барилд суралцаад, шоронгийн амьдралд дасан зохицоод гардаг гэж хэлэхэд нэг их хилсдэхгүй бизээ. Иймд уг асуудлыг шинжлэх ухаанчаар шинжлэн судалж, оношлох, учир шалтгаан, зүй тогтолыг илрүүлэх нь чухал зангилаа асуудлын нэг болоод байна. Уг асуудлын мөн чанарыг ял эдэлж буй бие хүн буюу ялтантай холбон тайлбарлахыг судлаачийн зүгээс эрмэлзсэн болно. Учир хүн бүр дахин давтагдашгүй өвөрмөц шинжүүдтэй. Нас, хүйс, боловсрол, мэргэжил, шашин шүтлэг, үйлдсэн гэмт хэрэг, анх давтан, ялын хугацаа, засрал хүмүүжлийн түвшин гэх мэт. Иймд ял эдлэгсдийг нийтлэг шинжүүдээр нь тодорхой төрөлд ангилж, хооронд нь холилдохгүйгээр ял эдлүүлэх тогтолцоог бий болгох шаардлагатай.

Өнөөгийн хорих ял эдлүүлэх үйл ажиллагаа нь ялтныг хооронд нь холих, шоронжуулах, ёс суртахууны төлөвшлийг улам эвдэхэд чиглэсэн механизм болон хувирчээ. Үүнийг шийдвэр гаргах төвшний хэн нэгэн, эсхүл хорих байгууллагын удирдлага, тэнд ажиллагсадтай холбон тайлбарлаж үл болно. Харин уг механизмийг бүрдүүлэгч эрх зүйн орчин, түүний зохицуулалтын арга, ял эдлүүлэх байгууллагын тогтолцоо, төрийн бодлоготой холбон тайлбарлах учиртай. Тухайлбал ялтныг дэглэм бууруулах, чангаруулах асуудал нь ялтны хүмүүжлийг дэмжих зорилготой боловч зан төлөвийн доголдолтой этгээдийг хорих анги өөрөөсөө зайлуулах хэрэгсэл, ёс суртахууны доголдол, гэмт зан үйлийг халдварыг тараах, ял эдлэгсдийг хооронд холих механизм болдог.

Анх удаа гэмт хэрэг үйлдсэн ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, засарч хүмүүжиж буй ялтныг засрал хүмүүжлээ олоогүй ялтнаас тусад ял эдлүүлэх тухай хуулийн заалт байгаа боловч өнөөгийн хорих байгууллагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтаас хамаарч хэрэгжүүлэх боломжгүй байна.

Илтгэлийн сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

#### А. Микро түвшинд.

1. Онцгой дэглэмтэй хорих ангид нийтийг хамарсан, зохион байгуулалттай гэмт явдал гарах магадлал өндөр байх тул харуул хамгаалалтын хүчийг нэмэгдүүлэх

2. Хүний нөөцийг тогтвор сууршилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр тусгайлсан бодлого хэрэгжүүлэх

3. Гар угастай холбоотой зөрчил гаргасан ялтанд сахилгын шийтгэл хүлээлгэх нь зүй ёсны асуудал мөн. Харин дэглэм чангаруулах нь оновчтой шийдвэр мөн үү? гэдэг асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж шийдэлд хүрэх.

4. Онцгой дэглэмтэй хорих ангийн аюулгүй байдлын түвшинг үнэлж мониторинг хийх

5. Аюулгүй байдлыг хангахтай холбоотой албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх

#### Б. Макро түвшинд

1. Хорих ял эдлэгсдийг 3 буюу 4 зэрэглэлд ангилж, тэдгээрийг хоорондоо холилдохгүйгээр ял эдлүүлдэг механизмийг бүрдүүлэх

2. Хорих байгууллагыг төвлөрсөн бүтцэд шилжүүлэх ажлыг шуурхайлах